



ЭРҮҮЛ МЭНД НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/1185

Улаанбаатар хот


Хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4, Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд нийгмийн даатгалын ерөнхий газрын "Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2015 оны А/107 тоот тушаалын 2 дугаар хавсралтыг хүчингүйд тооцож, шаардагдах зардлыг төсөвт тусгах, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах арга хэмжээ хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг Тамгын газар /Б.Батхуяг/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЗОРИГ

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий
газрын даргын 2017 оны 14 дугаар сарын
11-ны өдрийн АМБ тоот тушаалын
хавсралт

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр

Нэг. Хөтөлбөрийн зорилго

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдын ажиллаж амьдрах нөхцөл бололцоог сайжруулах, нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг сахин хамгаалахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

2.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим:

- 2.1.1. Төрийн алба, төрийн албан хаагчтай холбоотой хууль тогтоомжийн хүрээнд ажиллах
- 2.1.2. Төрийн албан хаагч нэг бүрийг хамруулах
- 2.1.3. Ил тод, нээлттэй хэрэгжүүлэх
- 2.1.4. Бодитой байх

2.2. Хамрах хүрээ:

Энэхүү хөтөлбөр Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагын нийт ажилтан /албан хаагч/-д хамаарна.

2.3. Хөтөлбөрийг 2017-2022 онд хэрэгжүүлнэ.

2.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар, эрүүл мэнд, нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллага хариуцна.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

3.1. Албан хаагчдыг орон сууцаар хангах, нөхцлийг сайжруулах чиглэлээр

3.1.1. Албан хаагчдын орон сууцны судалгааг жил бүр нарийвчлан гаргаж, түүнд үндэслэн орон сууц, хашаа байшин худалдан авах, шинээр барих, нөхцлөө сайжруулахад нь хууль тогтоомжийн хүрээнд байгууллагын зүгээс дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

3.1.2. Албан хаагчдыг амины сууцны болон зуслангийн газар эзэмшиж, өмчилж авахад нь байгууллагын зүгээс нэгдсэн зохион байгуулалтаар газрын асуудлыг шийдвэрлүүлэхэд анхаарч ажиллах, орон сууц /гэр, хашаа байшин/-тай болоход санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хууль тогтоомжид нийцүүлэн судлан шийдвэрлэнэ.

тохиолдолд байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд нийцүүлэн цалинтай чөлөө олгоно.

3.3. Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр

3.3.1. Албан хаагч /ажилтан/-ын эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт оруулах, шаардлагатай тохиолдолд ажилтнуудыг эмчлүүлэн сувилуулах тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

3.3.2. Албан хаагч /ажилтан/-дын бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор тэдний дунд спортын тэмцээн зохион байгуулах, долоо хоногт нэг удаа спорт зааланд тоглуулах, бүжгийн дугуйлан зэрэг төрөл бүрийн биеийн тамир, спортын арга хэмжээнд байгууллагын зүгээс дэмжлэг үзүүлж хамруулах, ажлын байран дахь дасгалыг өдөр бүр хийж хэвшүүлэх зэрэг спортын арга хэмжээг зохион байгуулна.

3.3.3. Албан хаагч /ажилтан/-д эрүүл мэнд, эрүүл аж төрөх ёс зэрэг сэдвээр тухайн мэргэжлийн багш нарыг урьж, мэдээллийн цагаар яриа, таниулга хийлгэх ажлыг зохион байгуулна.

3.4. Ажилтнуудын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрөөх чиглэлээр

3.4.1. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагын залуу мэргэжилтнүүдийн санал, санаачилгыг дэмжиж, тэднийг хөгжүүлэн чадавхижуулна. Салбартаа олон жил үр бүтээлтэй ажилласан албан хаагч /ажилтан/-дыг алдаршуулж, тэдний туршлага, арга зүйгээс нэвтрүүлнэ.

3.4.2. Баяр ёслол, амралтын өдрүүдийг хамт олноороо тэмдэглэн өнгөрүүлэх, аялал зугаалга, урлаг спортын арга хэмжээ зохион байгуулах зэргээр ажилтнуудын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх нөхцөл бололцоогоор хангана.

3.4.3. Нийгмийн хамгааллын ажилтны өдөр болон спорт биеийн тамирын нэгдсэн арга хэмжээнд албан хаагчдыг оролцуулах ажлыг зохион байгуулна.

3.4.4. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан албан хаагч /ажилтан/-дын 16 хүртэлх насны хүүхдүүдийн дунд уралдаан тэмцээн зохион байгуулах, мөн байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд нийцүүлэн урамшуулал олгоно.

3.4.5. Ажлын бүтээмж, шинэ санал санаачилгыг дэмжих, хөгжүүлэх зорилгоор албан хаагч /ажилтан/-дын дунд ажлын байрны орчин нөхцөл, байгууллагын маркетинг, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр болзолт уралдаан зарлаж, шалгаруулах, урамшуулах арга хэмжээ зохион байгуулна.

Дөрөв. Хөтөлбөрийн санхүүжилт

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

3.2. Ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх чиглэлээр

3.2.1. Ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах асуудлыг Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ.

3.2.2. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын конторын барилгыг засч сайжруулах, шинээр барьж ашиглалтад оруулах ажлыг холбогдох хууль, тогтоомж, батлагдсан төсөвт нийцүүлэн зохион байгуулна.

3.2.3. Албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмж, ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй нөхцлийг хангах, өрөө тасалгааг аятай, тохитой орчин үеийн оффисын стандартын жишигт нийцүүлэн тохижуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлж, ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.

3.2.4. Албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай материаллаг бааз, компьютер, техник хэрэгсэл, тавилга, эд хогшлоор хангах асуудлыг ажилтнуудаас санал авч судалгаа хийсний үндсэн дээр жил бүрийн төсөвт тусгах замаар шийдвэрлэнэ.

3.2.5. Ажилтнуудад ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгохоос гадна албан тушаал ахиулах, төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв хугацаанаас нь өмнө олгох, гадаад оронд сургалтанд хамруулах, туршлага судлуулах зэргээр хууль тогтоомжинд нийцүүлэн урамшуулна.

3.2.6. Ажилтан /албан хаагч/-ыг харилцагч банкуудаас цалин болон орон сууцны зээл авахад байгууллагаас дэмжлэг үзүүлнэ.

3.2.7. Олон улсын стандартад нийцсэн ISO 9001:2008 Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлнэ. Үүнд:

а. Өсөн дэвших эрмэлзэлтэй мэргэшсэн, чадварлаг, ёс зүйтэй хүний нөөцөд түшиглэн үйл ажиллагаагаа үргэлж сайжруулан, түншлэл хамтын ажиллагааг дэмжин, харилцан үр ашигтай хамтран ажиллах чанарын бодлого дэвшүүлж, албан хаагч /ажилтан/-ын шинэ санал санаачилгыг шалгаруулж хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

б. Ажлын байранд хэрэглэгддэг эмх цэгцтэй, дэг журамтай ажиллах алтан зарчим /5 S/-ыг нэвтрүүлнэ.

3.2.8. Ажилтан нь хагалгаа хийлгэх, эмчилгээ, сувилгаанд удаан хугацаагаар хамрагдахаар болсон, түүнчлэн эх орондоо хийлгэх боломжгүйн улмаас зайлшгүй гадаад улс оронд хийлгэх шаардлагатай эмнэлгийн шинжилгээ, өвчний онош тодруулахад буцалтгүй тусламжийн тодорхой хувийг холбогдох хууль тогтоомж, батлагдсан төсөвт нийцүүлэн шийдвэрлэж болно.

3.2.9. Ажилтан (албан хаагч) өөрөө болон ажилтны төрсөн эцэг (эх), эхнэр (нөхөр), хүүхэд нь нас барвал гэр бүлд нь буцалтгүй тусламжийг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд нийцүүлэн олгож болно.

3.2.10. Ар гэрт нь гачигдал гарах, биеийн эрүүл мэндийн байдлын улмаас эмчлүүлэх, сувилуулах, эцэг эхийн насны ой тэмдэглэх, ажилтан өөрөө буюу үр хүүхэд нь хуримаа хийх, диплом, эрдмийн зэрэг хамгаалах зэрэг хүндэтгэн үзэх шалтгаантай

4.1.1. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын жил бүрийн төсөв

4.1.2. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудын жил бүрийн төсөв

4.1.3. Төсөл, хөтөлбөр

4.1.4. Бусад эх үүсвэр

Тав. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэх

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт тавих, дүгнэх ажлыг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагын хэмжээнд Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар, эрүүл мэнд, нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын хэмжээнд тухайн хэлтэс /газар/-ийн дарга нар хариуцан гүйцэтгэнэ.

5.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар нийгмийн даатгалын байгууллагын удирдлага, албан хаагчид тодорхой санал хүсэлт гаргаж хөтөлбөрт тодотгол хийж нэмэлт оруулж болно.